



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 735

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн Шаамар сум дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой, 13 нэрийн, нийт 193,408,451.20 (нэг зуун ерэн гурван сая дөрвөн зуун найман мянга дөрвөн зуун тавин нэгэн төгрөг хорин мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 96,704,225.60 (ерэн зургаан сая долоон зуун дөрвөн мянга хоёр зуун хорин таван төгрөг жаран мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Сэлэнгэ аймгийн Шаамар сум дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Б.Хишигжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123007205
35-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 4 дугаар сарын 21-ны өдрийн
13 дугаар тогтоолын хавсралт

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР СУМ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭГДЭЛ ӨРТӨГГҮЙ, АШИГЛАХ ХУГАЦААГ СУНГАЖ
ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтанд орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Цаашид ашиглах хугацаа /жилээр/
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт үнэ (төгрөг)	
1	Верна аксент	2012	7,850,000.00	1	7,850,000.00	3,925,000.00	1	3,925,000.00	1
2	Симулятор	2012	109,778,451.20	1	109,778,451.20	54,889,225.60	1	54,889,225.60	3
3	Бага оврын трактор	2013	5,000,000.00	1	5,000,000.00	2,500,000.00	1	2,500,000.00	1
4	Компьютер оношлогооны техөөрөмж	2015	10,400,000.00	1	10,400,000.00	5,200,000.00	1	5,200,000.00	5
5	Втулк шахагч	2015	9,600,000.00	1	9,600,000.00	4,800,000.00	1	4,800,000.00	5
6	Тосгуур	2015	1,600,000.00	1	1,600,000.00	800,000.00	1	800,000.00	5
7	Редукторын тос солигч	2015	1,780,000.00	1	1,780,000.00	890,000.00	1	890,000.00	5
8	Кропны домкрат	2015	3,000,000.00	1	3,000,000.00	1,500,000.00	1	1,500,000.00	5
9	Рулийн гидрийн тос солигч	2015	4,100,000.00	1	4,100,000.00	2,050,000.00	1	2,050,000.00	5
10	4 хөлтэй тавцан лифт	2015	14,900,000.00	1	14,900,000.00	7,450,000.00	1	7,450,000.00	5
11	Тэнхлэг тохиргооны аппарат	2015	17,600,000.00	1	17,600,000.00	8,800,000.00	1	8,800,000.00	5
12	Дугуй задлагч	2015	4,100,000.00	1	4,100,000.00	2,050,000.00	1	2,050,000.00	5

Д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтанд орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Цаашид ашиглах хугацаа /жилээр/
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Нийт үнэ (төгрөг)	
13	Автомат кропны шингэн солигч	2015	3,700,000.00	1	3,700,000.00	1,850,000.00	1	1,850,000.00	5
	НИЙТ ДҮН			13	193,408,451.20 (нэг зуун ерэн гурван сая дөрвөн зуун найман мянга дөрвөн зуун тавин нэгэн төгрөг хорин мөнгө)		13	96,704,225.60 (ерэн зургаан сая долоон зуун дөрвөн мянга хоёр зуун хорин таван төгрөг жаран мөнгө)	